



2024 ЖИЛИЙН ТАЙЛАН

Агуулга

- 1 Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- 2 Бидний тухай
Монголын хөрөнгийн биржийн түүхэн товчоо
- 3 Бүтэц, зохион байгуулалт
Газруудын чиг үүрэг
Удирдлагын баг
Хүний нөөц
- 4 Компанийн засаглал
Компанийн ерөнхий мэдээлэл
Компанийн засаглал
- 5 ТУЗ-ын танилцуулга
ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ур чадвар
ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан
Мэдээллийн ил тод байдал
- 6 Хяналтын зөвлөлийн тайлан
- 7 Оны онцлох үйл явдлууд
- 8 Хөрөнгийн зах зээлийн тойм
- 9 Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны тойм
- 10 Санхүүгийн гол үзүүлэлтүүд
- 11 Санхүүгийн тайлан

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 1991 оны нэг сарын 18-ны өдрийн 22 тоот тогтоолоор Монголын хөрөнгийн биржийг үүсгэн байгуулж, мөн үеэс үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж ирсэн бол 2022 оны 12 сарын 23-ны өдөр Улсын Их Хурлаас "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль" баталж, эрх бүхий байгууллагаас уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноор бирж нь үнэт цаасны арилжаа, уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа эрхлэн, энэ хэрээр улс орны эдийн засагт оруулж буй манай хамт олны үнэ цэнэ нэмэгдэж, үйл ажиллагаа амжилттай өргөжин тэлж буйг дуулгахад таатай байна.

Биржийн хөгжлийн өнгөрсөн он жилүүдийн түүхийг зузаатгасан 2024 оны онцлох үйл явдлаас дурдал:

Арилжаа зохион байгуулалтын хувьд энэ онд нийт 250 удаагийн үнэт цаасны арилжаагаар нийт 1 их наяд 406.12 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас арилжлаа. Үүнээс хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 317.52 тэрбум төгрөг, өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаа 732.22 тэрбум төгрөг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа 61.63 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч арилжаа 10.89 тэрбум төгрөгт хүрсэн нь тус үнэт цаас бүрийн арилжааны хувьд түүхэн дээд үзүүлэлт боллоо.

Мөн 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 13 их наяд 017 тэрбум төгрөг буюу түүхэн дээд түвшинд хүрсэн бол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр ТОП-20 индекс 51,296.39 нэгжид хүрсэн түүхэн амжилтаар 2024 оныг үдсэн.

Түүнчлэн 2024 онд нийт 817 удаагийн арилжааг зохион байгуулсан, үүнээс 571 удаагийн арилжааны хэлцэл амжилттай хийгдэж, 24.8 сая тонн бүтээгдэхүүн арилжлаа. Тэр дундаа Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 73 дугаар тогтоолоор зэсийн баяжмалыг арилжаалах шийдвэр гарсны дагуу анх удаа "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын зэсийн баяжмалыг 4 дүгээр сараас, "Монголросцветмет" ТӨҮГ-ын хайлуур жоншны баяжмалыг 6 дугаар сараас амжилттай арилжаалж эхэлсэн.

Бүтээгдэхүүн тус бүрээр ангилбал 22.4 сая тонн нүүрс, 2.4 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 17.6 мянган тонн хайлуур жоншны хүдэр болон баяжмал, 6.0 мянган нойтон метр тонн зэсийн баяжмалыг тус тус арилжлаа. Нийт арилжааны 90.1 хувийг нүүрсний арилжаа, 9.8 хувийг төмрийн арилжаа, 0.07 хувийг хайлуур жоншны арилжаа, 0.03 хувийг зэсийн баяжмалын арилжаа тус тус эзэлж байлаа.

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолоор компанийн 2023 оны жилийн эцсийн аудитын өмнөх санхүүгийн тайлангийн татварын дараах

цэвэр ашиг болох 8,699,165,845 төгрөгөөс нийт 4,349,252,518.99 төгрөг буюу нэгж хувьцаанд 12 төгрөг 41 мөнгөөр тооцож 7000 гаруй хувьцаа эзэмшигчдэдээ анхны ногдол ашгийг хуваариллаа.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлд 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр нэгэн шинэ хуудас нээгдсэн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт батлагдсан үйл явдал байв. Тус хуульд банкны хадгаламжийн сертификат гаргах, олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл, мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулсан хаалттай хувьцаат компанийн хувьцааг биржээр арилжаалах, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх зэрэг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой зохицуулалтууд тусгагдсанаар МХБ-ийн эрхлэх үйл ажиллагааны хүрээ өргөжин тэлэх, хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүд нэвтрэх нөхцөл бүрдлээ.

Мөн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 89 тоот тогтоолоор нийслэлийн төсөвт тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор 500 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх "Улаанбаатар бонд"-ыг олон нийтэд нээлттэй санал болгосон нь Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдсан орон нутгийн анхны бонд боллоо.

Түүнчлэн дэлхий нийтийн чиг хандлага, ногоон тогтвортой санхүүгийн хэрэгслийг дэмжих чиглэлээр бирж нь "Үнэт цаасны бүртгэлийн журам"-даа зохицуулалтыг тусгасны дагуу нийт 3 төрлийн 40 сая ам.долларын үнийн дүн бүхий ногоон бонд гаргаснаар хамгийн олон ногоон бонд гарсан жил болсон юм.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдад Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг сурталчлах, чиглэлээр "Монголын хөрөнгийн бирж" ХК мөн чамгүй ажлуудыг зохион байгуулсан.

Тухайлбал, дотоодын үнэт цаасны зах зээлийн өдөрлөгийг АНУ-ын Нью-Йорк хотод, Сингапур улсад, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн талаарх сурталчилгааг БНХАУ, БНЭУ-д тус тус зохион байгуулж, Бээжингийн хөрөнгийн бирж, Шанхайн фьючерсийн бирж, Далианы таваарын бирж болон Истанбулын биржтэй хамтын ажиллагааг эхлүүллээ. Түүнчлэн биржийн мэргэжилтнүүдийн төлөөллийг гадаадын хөрөнгийн биржид туршлага судлах богино хугацааны сургалтуудад хамрууллаа.

Ийнхүү "Монголын хөрөнгийн бирж" ХК нь 34 жилийнхээ ойг тодорхой амжилт, өрнүүн хөдөлмөрөөр угтсан бөгөөд манай хамт олон хойшид ч Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн оролцогч мэргэжлийн байгууллагууд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид Та бүхэнтэй нягт хамтран ажиллаж Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил дэвшилд жинтэй үүрэг гүйцэтгэн, өмнөх он жилүүдийн ололт амжилтаа улам бататган, амжилт бүтээмжээр дүүрэн ажиллана гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлэе.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж. ЦОГТБАЯР

БИДНИЙ ТУХАЙ

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн түүхэн үед БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны нэг сарын 18-ны өдрийн 22 тоот тогтоолоор өмч хувьчлалын ажлыг хэрэгжүүлэх цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг үүсгэн байгуулсан билээ.

Улмаар 1992 онд Засгийн газрын өмч хувьчлалын бодлогын хүрээнд нийт 475 үйлдвэрийн газрыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, тэдгээрийн 8.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 96.1 сая ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулж иргэдэд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр эзэмшүүлсэн.

Үүний дүнд Монгол Улсын нийт хүн амын 52 хувь буюу 1.2 сая хүн хувьцаатай болж байсан түүхтэй.

Энэхүү үйл явц нь Монгол Улсын эдийн засгийн бүтцийг өөрчилж, үр ашгийг дээшлүүлэх, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох, эдийн засагт хувийн секторыг дэмжин хөгжүүлэх, өмч хувьчлалыг өргөн хүрээнд зохион байгуулах суурь нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу Монголын хөрөнгийн бирж олон улсад нэр хүнд бүхий "Лондонгийн хөрөнгийн бирж" групптэй стратегийн түвшинд хамтран ажиллаж, хөрөнгийн зах зээлийн зохицуулалт, техник технологи, дэд бүтцийн хувьд хөгжлийн шинэ түвшинд хүрсэн.

Үүгээр зогсохгүй 2013 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг шинэчилсний үр дүнд хууль эрхзүйн орчин ч олон улсын жишигт хүрч хөгжлөө.

Хууль эрх зүйн таатай орчин бий болсноор гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг компаниуд дотоодын хөрөнгийн биржид үнэт цаасны давхар бүртгэл хийлгэх боломж

бүрдэж, 2018 онд Монголын хөрөнгийн бирж дээр анхны давхар бүртгэл хийсэн түүхтэй.

Мөн хадгаламжийн бичиг, үнэт цаасны номинал болон бенефициар хөрөнгийн зах зээлд шинээр нэвтэрсэн.

2020 онд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжаалах зохицуулалтыг шинээр бүрдүүлж, хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг сайжруулж хариуцлагажуулах, төлбөр тооцооны дараа төлбөрт Т+2 горимыг амжилттай нэвтрүүлсэн.


Монголын хөрөнгийн бирж нь 1995 оны наймдугаар сарын 28-ны өдөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлснээс хойш 2024 оны эцсийн байдлаар нийт 7.52 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжааг зохион байгуулж, 30 жилийнхээ ойг түүхэн дээд амжилт, голлох үзүүлэлтүүдийн онцгой өсөлтөөр үдэж байв.

Түүнчлэн 2021 оны эхэнд Банкны тухай хууль шинэчлэгдэж, системийн нөлөө бүхий банкууд олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжин, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, зах зээлд олон улсын стандарт нэвтрүүлэх зорилгоор, дэлхийн шилдэг хөрөнгийн биржийн нэг Шанхайн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагааг эхлүүлсэн.

Харин 2022 онд Монголын Хөрөнгийн Бирж төдийгүй хөрөнгийн зах зээлд онцгой нөлөө үзүүлэх хэд хэдэн үйл явц өрнөсөн. Тухайлбал, олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч "FTSE Russell" группээс 2022 оны 9-р сарын 29-ний өдөр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг FTSE Russell-ийн "Хөгжиж буй" (Frontier Market) зах зээлийн зэрэглэлийн шалгуурыг бүрэн хангасан тул 2023 оны 9 дүгээр сараас эхлэн тус ангилалд оруулахыг зөвшөөрсөн юм.



1991 он



2021 он

БИДНИЙ ТУХАЙ

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд, засаглал сайжруулах чиглэлд төрийн өмчит компаниудаас нэн тэргүүнд Монголын Хөрөнгийн Биржийг олон нийтэд нээлттэй компани болгох шийдвэрийг гаргаж, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК нь нийт хувьцааныхаа 34 хувийг олон нийтэд санал болгон, олон нийтийн өмчийн оролцоотой компани болсон.

Ингэснээр “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц шинэчлэгдэж, олон нийтийн хараа хяналт, ашигт ажиллагаа, компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал сайжирч, гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг дотоодын зах зээлд татах боломжийг нээх хөгжлийн шинэ түүхийг эхлүүлсэн.

2023 онд Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд системийн 5 банк болох Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк, Төрийн банк, Голомт банкууд нээлттэй компани болж, олон нийтэд хувьцаагаа санал болгосноор нийт 446.79 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Улсын Их Хурлаас “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль” баталж, 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос “Монголын хөрөнгийн бирж” ХК-д уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосноор МХБ арилжааны системийн шинэчлэлт хийн, үйл ажиллагаагаа өргөжүүлж, Монгол Улсад анхны уул уурхайн бүтээгдэхүүний бирж үүсч, үйл ажиллагаа нь жигдэрлээ.

Түүнчэн МХБ-ээр арилжигдсан уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны үнийн мэдээллийг эх сурвалж болгон “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр”/АМНАТ/ тооцдог болсон. МХБ-ээр дамжин экспортод гарах уул уурхайн бүтээгдэхүүний нэр, төрөл нэмэгдэж төмрийн баяжмал арилжаалж эхэлсэн бол 2024 онд зэсийн баяжмал болон хайлуур жонш арилжаалж эхэллээ.

2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт батлагдаж, тус хуульд хувьцааны хамтын санхүүжилт, банкны хадгаламжийн сертификат гаргах, олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл, мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулсан хаалттай хувьцаат компанийн хувьцааг биржээр арилжаалах, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх зэрэг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой зохицуулалтууд тусгагдсанаар МХБ-ийн эрхлэх үйл ажиллагааны хүрээ өргөжин тэлэх, хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүд нэвтрэх нөхцөл бүрдээд байна.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдад Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг сурталчлах, чиглэлээр Монголын хөрөнгийн бирж 2024 онд нэлээд ажлуудыг зохион байгуулсан.

Тухайлбал, 2024 оны 4 дүгээр сард АНУ-ын Нью-Йорк хотод, 11 дүгээр сард Сингапур улсад дотоодын үнэт цаасны зах зээлийн өдөрлөгийг зохион байгуулсан бол, энэ онд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн талаарх сурталчилгааг БНХАУ, БНЭУ-д тус тус зохион байгууллаа.

Түүнчлэн Бээжингийн хөрөнгийн бирж, Шанхайн фьючерсийн бирж, Далианы таваарын бирж болон Истанбулын биржтэй хамтын ажиллагааг эхлүүлэв.

МХБ нь 2024 онд Үнэт цаасны арилжаагаар нийт 1 их наяд 406.12 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас арилжсан бол Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаагаар 8 их наяд 894.29 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжааг амжилттай зохион байгуулсан байна.

2022 ОН	2023 ОН	2024 ОН
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ		
6.89 их наяд	11.6 их наяд	13.0 их наяд
ТОП-20 ИНДЕКС		
37,565.55 нэгж	41,437.42 нэгж	51 296.39 нэгж
БҮТГЭЛТЭЙ КОМПАНИЙН ТОО		
183 ХК	173 ХК	172 ХК
ӨДРИЙН ДУНДАЖ АРИЛЖАА		
2.4 ТЭРБУМ	33.3 ТЭРБУМ	45.15 ТЭРБУМ

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ТҮҮХЭН ТОВЧОО

1991.01.18

Монголын хөрөнгийн бирж байгуулагдав.

1992.02.07

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа эхлэв.

1994.09.26

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдв.

2013.10.03

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдлаа.

2013.05.24

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдв.

2012.07.02

Арилжаа, Төлбөр Тооцоо, Хяналт, Хадгаламжийн “Миллениум Ай Ти” цогц системийг зах зээлд нэвтрүүллээ

2015.12.02

Монголын хөрөнгийн бирж өөрийгөө зохицуулах байгууллага боллоо.

2016.01.05

Төрийн өмчийн хувьчлалыг хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй явуулж эхлэв.

2018.01.02

MSE A болон MSE B индексүүдийг тооцож эхлэв.

2022.12.26

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нэмэлт хувьцаагаа олон нийтэд санал болголоо.

2022.09.29

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг FTSE Russell-ийн “Frontier Market” ангилалд оруулахыг зөвшөөрлөө.

2022.05.10

Бүртгэлтэй компаниуд сайн дурын үндсэн дээр ESG буюу Байгаль Орчин Нийгэм Засаглалын тайлагналын стандартыг мөрдөхөөр болов.

2023.05.29

Системийн нөлөө бүхий банкууд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан IPO гаргалаа.

2023.06.29

Шанхайн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

2023.06.30

Санхүүгийн зохицуулах хорооноос “Монголын хөрөнгийн бирж” ХК-д уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олголоо.

2024

Монголын хөрөнгийн бирж дээр хамгийн олон ногоон бонд арилжигдсан түүхэн үзүүлэлт тогтоов.

2024.10.04

“Монголын хөрөнгийн бирж” ХК ISO/IEC 27001:2023 / ISO/IEC 27001:2022 стандартыг нэвтрүүллээ

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ТҮҮХЭН ТОВЧОО

1995.08.28

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэв.

1996.10.25

Засгийн газрын бондыг Монголын хөрөнгийн биржээр арилжаалж эхлэв.

1999

TOP-75 индекс тооцож эхлэв.

2011.04.27

Лондонгийн хөрөнгийн бирж групптэй стратегийн түншлэлийн “Ажлын мастер гэрээ” байгуулав.

2005.05.25

Анхны IPO амжилттай хийгдэв.

2001.06.08

Анхны компанийн бондыг арилжаалав.

2018.04.04

Хамгийн анхны гадаадын үнэт цаасыг давхар бүртгэв.

2019.06.28

“Хамтын хаалттай хөрөнгө оруулалттай сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ыг батлав.

2020.03.31

Төлбөр тооцооны T+2 горимд шилжлээ.

2022.04.29

Монгол Улсын Их Хурлаас “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийг батлав

2020.11.12

Анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэгдлээ.

2020.08.24

Анхны хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх бүртгэгдлээ.

2023.11.24

Монголын хөрөнгийн зах зээлийн өдөрлөгийг Шанхай хотноо зохион байгууллаа.

2023.12.28

Монголын хөрөнгийн биржийн нийт арилжаа, зах зээлийн үнэлгээ түүхэн дээд амжилт үзүүллээ.

2024.04.25

Монголын хөрөнгийн бирж 7000 гаруй хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилав

2024.06.20

Монголын хөрөнгийн биржид анх удаа орон нутгийн бонд бүртгэгдэн, амжилттай арилжигдлаа.


2024.05.16

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орлоо

2024.04.29

Зэсийн баяжмал, хайлуур жонш биржээр анх удаа арилжигдаж эхлэв.


БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Захиргаа, санхүүгийн газар нь компанийн дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалт, уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны төлбөр тооцоо болон санхүүгийн үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж ажиллах ба чиг үүргээрээ Захиргааны алба, Санхүүгийн алба, Хуулийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Үйл ажиллагааны газар нь үнэт цаасны арилжааны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, хөрөнгийн биржийн мэдээллийн технологийн дэд бүтцийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах үндсэн чиг үүрэг бүхий Арилжааны алба, Мэдээлэл технологийн албаны бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Уул уурхайн бүтээгдэхүүний бүртгэлийн газар бүтээгдэхүүнийг бүртгэж, зээлд оролцогчдыг бичиглэх, арилжааны зуучлалтыг зохион байгуулах, зөвшөөрөлтэй этгээд бүтээгдэхүүний арилжааны элсүүлэх, тэдгээрийн хяналт тавих, журам хүлээсэн үүргийн хэрэг ажиллах чиглэлээр явуулдаг.



ЗЭГЭГДЭХҮҮНИЙ арилжаа, нь уул уурхайн гэх, арилжих, зах зээл, итгэмжлэх, агчийн тусгай ийг уул уурхайн жааны гишүүнээр үйл ажиллагаанд болон гэрээгээр гжилтийг хангуулан үйл ажиллагаа

Бизнес хөгжлийн газар нь Маркетинг, олон нийттэй харилцах алба, Зах зээлийн хөгжлийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулж, салбарын төлөв байдал, олон улсын чиг хандлагад тулгуурлан биржийн стратеги, бизнес төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилладаг. Түүнчлэн биржийн өдөр тутмын үйл ажиллагаа, хөрөнгийн зах зээлийн талаарх цаг үеийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх, зах зээлийг идэвхжүүлэх, сурталчлан таниулах үйл ажиллагаа, хөрөнгийн зах зээлийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулдаг.

Хяналт, зохицуулалтын газар нь бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой үнэт цаас гаргагч байгууллагууд, гишүүн үнэт цаасны компани, арилжааны хяналт, хөрөнгийн зах зээлийн эрсдэлийн үнэлгээ хийх чиг үүрэгтэйгээр Хяналт шинжилгээний алба, Бүртгэлийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж байна.

УДИРДЛАГЫН БАГ



Ж. Цогтбаяр
Гүйцэтгэх захирлын үүргийг түр
орлон гүйцэтгэгч

2024 оны 01 дүгээр сараас эхлэн "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн
Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Боловсрол:

- **2005-2008** Магистр, Бизнесийн удирдлага, Виржиниагийн ОУ-ын Их Сургууль, Америк
- **2001-2002** Магистр, Төрийн удирдлага, Удирдлагын академи, Монгол Улс
- **1992-1994** Бакалавр, Санхүүч-Эдийн засагч, Монгол Улсын Их Сургууль, Монгол Улс

Ажлын туршлага:

- **2014-2023** Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Хэлтсийн дарга
- **2002-2014** Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга
- **2000-2002** Санхүүгийн Хяналт Шалгалтын Газрын Даатгалын хяналтын албаны дарга
- **1994-2000** Сангийн яамны Улсын байцаагч



Т. Хаш-Эрдэнэ
Бизнес хөгжлийн газрын захирал

2022 оноос эхлэн "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Бизнес хөгжлийн газрын захирал

Боловсрол:

- **2001-2005** Олон улсын ЭЗ-ийн харилцаа, Бакалавр, РУДН ОХУ
- **2019-2023** Эрх зүйч, Бакалавр, МУИС-ийн Хууль зүйн сургууль Монгол Улс
- **2023-2025** Магистрант, Хөрөнгө оруулалтын менежмент, Санхүү эдийн засгийн их сургууль

Ажлын туршлага:

- **2021-2022** "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Дэд захирал
- **2021** ЗГХЭГ, МУ-ын Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлого хариуцсан зөвлөх
- **2018-2021** ЗГХЭГ, МУ-ын Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн бодлогын зөвлөлийн Ажлын албаны дарга
- **2017-2018** Ерөнхий сайдын Олон нийттэй харилцах бодлого хариуцсан орон тооны бус зөвлөх
- **2012-2017** "Монгол медиа корпораци" ХХК-ийн Газрын захирал



А. Мөнхбаясгалан
Хяналт, зохицуулалтын газрын захирал

2017 оноос эхлэн "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хяналт, зохицуулалтын газрын захирал

Боловсрол:

- **1994-1999** Бизнесийн удирдлага Бакалавр, Парисын 9 дүгээр их сургууль Франц улс
- **1999-2000** Төрийн удирдлага, Магистр Парисын 9 дүгээр их сургууль Франц улс

Ажлын туршлага:

- **2015-2017** Сангийн яамны газрын дарга
- **2006-2015** ХХБ ХХК-ийн Газрын захирал
- **2005-2006** Үйлдвэр, худалдааны яамны мэргэжилтэн
- **2004-2005** СЗЗДС-ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн Бизнесийн удирдлагын багш

УДИРДЛАГЫН БАГ

2020 оноос эхлэн "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал

Боловсрол:

- 2016 Санхүүгийн удирдлага, магистр, Мельбурнийн Их сургууль, Австрали улс
- 2005-2009 Олон улсын эдийн засгийн харилцаа Бакалавр, МУИС-ОУХС, Монгол Улс

Ажлын туршлага:

- 2017-2020 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Зах зээл хөгжийн албаны Ахлах мэргэжилтэн
- 2011-2015 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Бүртгэлийн албаны Ахлах мэргэжилтэн



И. Жавхлан

Үйл ажиллагааны газрын захирал

2023 оноос эхлэн "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Захиргаа, санхүүгийн газрын захирал

Боловсрол:

- 2014-2016 Эдийн засгийн үндэсний дээд сургууль, Бизнес удирдлагын магистр
- 1993-1997 МУИС, Банкны эдийн засагч, мэдээлэл зүйч

Ажлын туршлага:

- 2023 оноос "Монголын хөрөнгийн бирж" ХК, Захиргаа, санхүүгийн газрын захирал
- 2020-2023 "Монголын хөрөнгийн бирж" ХК, Санхүүгийн албаны ахлах мэргэжилтэн
- 2015-2017 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, Санхүүгийн албаны дарга
- 2005-2015 "Өнө-Ингүмэл ББСБ" ХХК, Гүйцэтгэх захирал
- 1999-2005 Тээвэр хөгжлийн банк, Салбарын захирал
- 1998-1999 Улаанбаатар хотын банк, Нягтлан бодогч



Х. Эрдэнэбүрэн

Захиргаа, санхүүгийн газрын захирал

2024 оноос эхлэн "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа бүртгэлийн газрын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Боловсрол:

- 2010-2011 Бизнесийн удирдлагын магистр, АНУ Life university
- 2003-2007 Бизнесийн удирдлага, Бакалавр, СЭЗДС, Монгол Улс

Ажлын туршлага:

- 2022-2024 "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Маркетинг, олон нийттэй харилцах албаны Бизнес хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн
- 2018-2022 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн хяналт шинжилгээний албанд Бодлого, эрсдэл хариуцсан мэргэжилтэн
- 2014-2018 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Бүтээгдэхүүн хөгжлийн албаны мэргэжилтэн
- 2013-2014 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Зах зээлийн хөгжлийн газарт судалгааны албаны ахлах мэргэжилтэн
- 2011-2013 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Мэдээлэл, олон нийттэй харилцах албанд ахлах мэргэжилтэн
- 2008-2011 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Арилжааны албаны мэргэжилтэн



С. Ариунсанаа

Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа бүртгэлийн газрын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

ХҮНИЙ НӨӨЦ

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийг орчин үеийн хүний нөөцийн удирдлагын чиг хандлага, байгууллагын ажилтнуудын зан төлөвт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аливаа байгууллагын үндсэн үүргийн хувиар ажилтнуудын боловсрол, мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалт зохион байгуулж, мөн нэмэлт ур чадварыг бий болгох чиглэлийг дэмжин ажиллав.

Хүний нөөцийн хөдөлгөөн, хуваарилалтыг амжилттай хэрэгжүүлснээр **2024 оны эцэст нийт 72 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.**



72

Нийт ажилтан



46

Нийт эмэгтэй ажилтан



26

Нийт эрэгтэй ажилтан



45

Үндсэн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн



27

Дэмжих үйл ажиллагааны мэргэжилтнүүд



36

Дундаж нас



8жил

Ажилласан дундаж хугацаа



24

Удаагийн сургалт



67

Дээд боловсрол

20

Магистр

43

Бакалавр

4

Магистрантур

5

Тусгай дунд



МОНГОЛЫН МЭРГЭШСЭН
НЯГТЛАН БОДОГЧДЫН
ИНСТИТУТ

3

Мэргэшсэн
нягтлан бодогч



CFA Institute

2

Олон улсын
итгэмжлэгдсэн
санхүүгийн шинжээч
цол горилогч



1

Олон улсын
мэргэшсэн
компьютерийн
сүлжээний инженер

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



Оноосон нэр:
"Монголын хөрөнгийн бирж" ХК
"Mongolian Stock Exchange" JSC

Хэлбэр:
Нээлттэй хувьцаат компани



Регистрийн дугаар:
2071096



Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:
Монголын Хөрөнгийн бирж

Хувьцааны бүртгэлийн ангилал:
I

Симбол:
MSE

Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:
350,463,539

ISIN дугаар:
MN00MSE05100

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:

- Санхүү
- К 66 Санхүүгийн бусад үйл ажиллагаа

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

2024 он

8,829

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



231,305,936
Хувьцааны тоо ширхэг



119,157,603
Хувьцааны тоо ширхэг

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн эрх барих дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчид байна. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 26 -ны өдөр "Монголын хөрөнгийн бирж" ХК -ийн төв байр болон www.AGM.mn цахим хуудсаар дамжуулан 09 цаг 10 минутаас 11 цаг 55 минутын хооронд 2 цаг 45 минутын турш 71.68%-ийн ирцтэй хуралдаж, зохих шийдвэрүүдийг гаргав.

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн 38.5 сая ширхэг үнэт цаас нийт 10.6 тэрбум төгрөгөөр арилжигдлаа. Компанийн зах зээлийн үнэлгээ 2024 оны эцэст 124 тэрбум 78 сая төгрөгт хүрснээр зах зээлийн үнэлгээгээр 16-р байрт эрэмбэлэгдлээ.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг.

ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, томилох, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй.

Компанийн дунд хугацааны төлөвлөлт буюу 2023-2027 оны стратегийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллалаа.

Тайлант хугацаанд МХБ-ийн гүйцэтгэх удирдлагын баг үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тогтмол хуралдсан байна.

ТУЗ-ийн үүргийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн дүрэм болон "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-д тодорхой заасан байдаг.

ТУЗ-ийн хороод

ТУЗ нь дэргэдээ тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 4 хороотой ба өдгөөр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн чиг үүрэгтэй.

Хороодын үйл ажиллагааг "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-аар зохицуулдаг.

ТУЗ нь дараах байнгын хороодтой:

- Эрсдэлийн удирдлагын хороо;
- Нэр дэвшүүлэх хороо;
- Аудитын хороо;
- Цалин, урамшууллын хороо.

ТУЗ-ийн гишүүд нь нэгээс доошгүй хороонд орж ажилладаг бөгөөд хорооны нийт гишүүдийн 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүдээс бүрдэж байна.

Аудитын хорооны бүрэлдэхүүн

Н. Улаанхүү	Хорооны дарга
Р. Мөнхтөр	Гишүүн
Ж. Цогтбаяр	Гишүүн

Цалин, урамшууллын хорооны бүрэлдэхүүн

Р. Мөнхтөр	Хорооны дарга
Н. Улаанхүү	Гишүүн
С. Баянцогт	Гишүүн

Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн

Н. Отгончимэг	Хорооны дарга
М. Банзрагч	Гишүүн
Т. Ганбаатар	Гишүүн

Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн

М. Банзрагч	Хорооны дарга
Н. Отгончимэг	Гишүүн
Ж. Бямбасүрэн	Гишүүн

ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, шинэчлэх.

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хараат бус үнэлгээ дүгнэлт гаргах зорилгоор нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлагыг хянан шалгаж, гишүүдийн ур чадвар, туршлага нь МХБ-ийн үйл ажиллагааны стратеги зорилго, зорилт, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хангаж ажиллахад зохистой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгч ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр оруулах гишүүнийг нэр дэвшүүлдэг. Гишүүдийг томилохоос өмнө Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмын дагуу боловсрол, ур чадвар, өмнөх ажил эрхлэлтийн түүх, гэмт хэрэгт холбогдсон эсэх зэрэг асуудлаар цогц судалгаа, шинжилгээг хийж ажилладаг.

ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, улируулан сонгох

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчид нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгон 3 жилийн хугацаагаар томилж, Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан ТУЗ-ийн гишүүнийг орлох гишүүнийг нөхөн сонгох хүртэл ТУЗ түр томилж болдог. 2023 оны 6-р сарын 30-ны өдрөөс Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчид нээлттэй сонгон шалгаруулалтаар дараах гишүүдийг сонгож 3-н жилийн хугацаатай томилсон.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилдог. 2024 онд уг албан тушаалыг эрхэлж байгаа этгээдэд өөрчлөгдөөгүй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА, БҮТЭЦ, УР ЧАДВАР

НЭР	АЛБАН ТУШААЛ	Томилогдсон огноо
1 Д.ТОГТОХБАЯР ТУЗ-ийн дарга	МУБИС-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга	2023.06.30
2 С.БАЯНЦОГТ Ердийн гишүүн	"Алтайн зам" ХК-ийн Санхүүгийн хэлтсийн захирал	2023.06.30
3 Ж.БЯМБАСҮРЭН Ердийн гишүүн	ЗГХЭГ-ын Санхүү, эдийн засгийн газрын дарга	2023.06.30
4 Т.ГАНБААТАР Ердийн гишүүн	УУХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга	2023.06.30
5 Ж.ЦОГТБАЯР Ердийн гишүүн	Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга	2023.06.30
6 М.БАНЗРАГЧ Хараат бус гишүүн	ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн Сургалт, чанарын албаны дарга	2023.06.30
7 Р.МӨНХТӨР Хараат бус гишүүн	"Айкор партнерс" ХХК-ийн Дэд захирал	2023.06.30
8 Н.ОТГОНЧИМЭГ Хараат бус гишүүн	"Сүлд-Аудит" ХХК-ийн Аудитор	2023.06.30
9 Н.УЛААНХҮҮ Хараат бус гишүүн	Ландбридж" ХХК-ийн Санхүү, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал	2023.06.30
Хяналтын зөвлөлийн гишүүд		
1 Д. БАТБАЯР	"Ди Си Эф ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал	2023.06.30
2 Б. ТУЯАРАХ	"Эрдэнэс Ассет Менежмент ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал	2023.06.30
3 Ц. МӨНХЗУЛ	Монгол Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуулийн Ахлах хуулийн зөвлөх	2023.06.30


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д заасны дагуу 5 ердийн гишүүн, 4 хараат бус гишүүдээс бүрддэг.


2023 оны 6-р сарын 30-ны өдрөөс Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчид нээлттэй сонгон шалгаруулалтаар ТУЗ-ийн гишүүдийг сонгож 3-н жилийн хугацаатай томилсон.

ТУЗ-ийн нийт гишүүдийн 22% нь эмэгтэй гишүүд ба гишүүдийн насны бүтэц, ажилласан жилийг дараах байдлаар үзүүлээ.

Гишүүдийн нас



Гишүүнээр ажилласан хугацаа



➔ ГИШҮҮДИЙН УР ЧАДВАРЫН МАТРИЦ

		Эдгээр ур чадварыг эзэмшсэн байдал								
Төрөл	Тайлбар	1	2	3	4	5	6	7	8	9
Манлайлал	Гүйцэтгэх удирдлагын чиглэлээр амжилттай ажилласан туршлага									
Стратеги	Стратегийн зорилго, зорилтыг тодорхойлох, бизнес төлөвлөгөөг судлах, шинжлэх, стратегийг хэрэгжүүлэх									
Санхүүгийн ур чадвар	Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагнал, компанийн санхүү болон дотоод хяналт									
Эрсдэл ба комплаенс	Үйл ажиллагааны үндсэн эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдлыг хянах									
Төрийн/Нийтийн удирдлага	Зах зээл болон компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх зохицуулалт									
Мэдээллийн технологи	Мэдээллийн технологийн дэд бүтэц, хэрэглээ, засаглал									
Бизнесийн хөгжил, харилцагчийн удирдлага	Бизнесийн туршлага (шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт, харилцагчийн удирдлагын стратеги, болон инноваци)									
Хувь хүний хөгжлийн удирдлага	Удирдлагын баг, цалин урамшууллын тогтолцоо, хүний нөөцийн удирдлага болон стратегийг үнэлэх, хянах									
Компанийн засаглал	Компанийн засаглалын чиглэлээрх мэдлэг, туршлага, болон ажилласан байдал									
Олон улсын хөрөнгийн зах зээлийн туршлага	Олон улсын санхүүгийн зах зээл, хөрөнгийн бирж /групп, эсхүл бусад мэргэжлийн оролцогч байгууллагуудтай хамтран ажилласан байдал									
Санхүүгийн үйлчилгээний чиглэлээр ажилласан туршлага	Брокер дилерийн компани, хөрөнгө оруулалтын менежментийн компани, банк, хөрөнгө оруулалтын банк г.м									

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН УР ЧАДВАР, ТУРШЛАГА

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах гишүүдийн хамтын ур чадварт байж болох ур чадварын дутуу орон зайг илрүүлэх, гишүүдийн ур чадвар, ажлын туршлагыг үнэлэх зорилгоор өмнөх хүснэгтээр харуулсан матрицыг хэрэглэдэг.

Гишүүдийн салбарын мэдлэг туршлага, мэргэжлийн ур чадвар болон хүйсийн тэнцвэртэй харьцааг хадгалах нь МХБ-д тулгарч байгаа асуудал, сорилтуудыг оновчтойгоор шийдвэрлэх, гүйцэтгэх захирал болоод удирдлагын багийн бусад гишүүд үйл ажиллагааны стратеги төлөвлөлтийг хэрхэн хэрэгжүүлж байгаад бодит үнэлгээ, дүгнэлт өгөхөд чухал үүрэгтэй.

ТУЗ өөрийн бүтэц, бүрэлдэхүүнийг зохих түвшинд байна гэж үзсэн бөгөөд компанийн сайн засаглалын зарчмын дагуу ур чадвар, бүтэц, бүрэлдэхүүний тэнцвэртэй байдлыг ханган ажиллаж ирсэн.

ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

"Компанийн тухай хууль"-ийн 75.9 дэх зүйлд заасны дагуу МХБ-ийн ТУЗ-ийн гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдаж, сургалтын гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд энэхүү шаардлагын дагуу 2023 онд шинээр томилогдсон ТУЗ-ийн бүх гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдан гэрчилгээг авсан байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. 2024 онд ТУЗ нийт 22 удаа хуралдсан. ТУЗ-ийн хурлаар нийт 90 гаруй асуудал хэлэлцэн, компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн дотоод ажилтай холбоотой 63 тогтоол гаргаж, 30 тэмдэглэлээр гүйцэтгэх удирдлагад үүрэг, даалгавар өгч ажилласан.

ТУЗ-ийн 22 удаагийн хурал Улаанбаатар хотод МХБ-ийн хурлын танхим болон цахим хосолсон хэлбэрээр явагдсан байна.

ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн гишүүдэд сар бүр тогтмол цалин хөлс олгодог. Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагч ердийн гишүүдэд цалин хөлснөөс бусад шан харамж, урамшуулал авахыг хориглодог тул ердийн гишүүний цалин, урамшуулал нь зөвхөн цалин хөлснөөс бүрддэг.

ТУЗ-ийн гишүүний цалин хөлсний хэмжээг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын дагуу тогтоодог ба гишүүдийн цалин хөлсний дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байдаг.

МХБ-ийн хараат бус гишүүд болон хяналтын зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын бүтэц ердийн гишүүдийн цалин урамшууллын бүтэцтэй адил байна. ТУЗ-ийн гишүүнд зуучлалын хөлс, зөвлөх үйлчилгээний хөлс зэрэг бусад төлбөр, нөхөн олговор олгодоггүй.

ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ

1	ТУЗ-ийн дарга	1,320,000₮
2	Ердийн гишүүд	1,300,000₮
3	Хараат бус гишүүд	1,300,000₮
4	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1,370,800₮

1 сарын цалин хөлс, ₮

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

➔ Ашиг сонирхлын зөрчил

Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу гишүүд эзэмшиж байгаа үнэт цаасны талаарх мэдээллийг ил тод танилцуулах үүрэгтэй. Түүнчлэн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар гишүүн бүр Авлигатай тэмцэх газар ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг өгдөг. Мөн ТУЗ-ийн гишүүн хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд тухайн асуудалд санал өгөхөөс татгалзах үүрэгтэй.

➔ Гишүүдийн бие даасан байдал

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнд хараат бус гишүүн олон байх нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт эерэг нөлөөтэй. МХБ-ийн ТУЗ нь “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль”-ийн 7.1 дэх заалтын дагуу хараат бус 4 гишүүнтэй байна. Нэр дэвшүүлэх хороо шинэ гишүүний танилцуулга, холбогдох баримт материалыг “Авлигатай тэмцэх газар”-т /АТГ/ хүргүүлэн гишүүний бие даасан байдлыг тодорхойлуулдаг. АТГ нь гишүүд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн төлөө ажиллахад, мөн бие даасан үйл ажиллагаа явуулахад материаллагаар нөлөөлж болох ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг хянаж шалгадаг.

➔ Хараат бус аудит

МХБ-ийн ТУЗ-ийн аудитын хорооноос шалгаруулан хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн сонгосон хараат бус аудитын итгэмжлэгдсэн байгууллага болох “Грант Торнтон Аудит” ХХК -тай “Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулж, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудит хийсэн.

Тус аудитын байгууллага МХБ-ийн санхүүгийн тайлагналын үйл ажиллагааг шалган санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнг үнэн зөв илэрхийлсэн, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон компанийн тухай хууль тогтоомжийг дагаж мөрдсөн эсэх талаар дүгнэлт гаргах үүрэгтэй.

Аудитын баг нь МХБ-ээс ажил төрөл, хувийн харилцаа холбооны хувьд мөн аудитын үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдсон нөхцөл байдлын хувьд хараат бус байсан тухайгаа илэрхийлсэн. Хараат бус аудитын дүгнэлтийг ...-р хуудаснаас үзнэ үү.

➔ Мэдээллийн ил тод байдал

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь үнэт цаасны 1 дүгээр ангилалд бүртгэлтэй компани тул Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Мэдээллийн ил тод байдлын журам”-ын дагуу жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэн нийтэд толилуулах үүрэгтэй.

“Компанийн тухай хууль”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн дагуу хувьцаа эзэмшигч, зах зээлд оролцогч байгууллагууд, иргэдийг жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайлан, үйл ажиллагааны тойм танилцуулга, сар тутмын гол үйл явдлуудын эмхэтгэл зэрэг үйл ажиллагааны мэдээллээс гадна хөрөнгийн зах зээлийн өдөр

тутмын үйл явдлын мэдээ, мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан монгол, англи хэлээр, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг монгол, англи, хятад хэлээр тогтмол хүргэдэг бөгөөд олон нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг тухайлчлан зарим этгээдэд мэдээлдэггүй.



ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хяналтын зөвлөлийн чиг үүрэг

"Монголын хөрөнгийн бирж" нээлттэй хувьцаат компанийн дүрэм болон хяналтын зөвлөлийн ажиллах журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах, хувьцаа эзэмшигчдээс компанийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэгтэй. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хуулийн дагуу хамгаалах чиглэлээр санал гаргаж ТУЗ-д хүргүүлэх,

- Хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд дүгнэлт, зөвлөмж гаргаж ТУЗ-д хүргүүлэх,

- Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу зөвлөмж гаргаж компанийн гүйцэтгэх захиралд хүргүүлэх.

Хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн

Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрээр томилогдсон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс бусад хувьцаа эзэмшигчийн төлөөлөл бүхий 3 (гурав) гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Цалин урамшуулал

Хяналтын зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал нь зөвхөн цалин хөлснөөс бүрддэг. Зөвлөлийн гишүүний цалин хөлсний хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоодог ба зөвлөлийн гишүүдийн цалин хөлсний дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байдаг. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор зөвлөлийн гишүүний цалинг тухайн сард хуралдсан эсэхээс хамааруулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоосон. Хяналтын зөвлөлийн гишүүдэд олгосон цалин хөлсийг дараах хүснэгтээр харуулав.

Цалин урамшуулал

1 сарын цалин хөлс, ₮

Хяналтын зөвлөлийн дарга	1,320,000
Хяналтын зөвлөлийн гишүүд	1,320,000

Хяналтын зөвлөлийн гишүүд

Д. Батбаяр	"Ди Си Эф ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал	2023.06.30
Б.Туярах	Дэлхийн банкны зөвлөх	2023.06.30
Ц. Мөнхзул	Хуульч, өмгөөлөгч	2023.06.30

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ АЖИЛЛАСАН БАЙДЛЫН ТОВЧ ТАЙЛАН

Хувьцаа эзэмшигчийн эрх, ашиг сонирхолд нийцэх, хамгаалах талаар тухай бүр дүгнэлт, санал, зөвлөмж гаргаж холбогдох этгээдүүдэд хүргүүлсэн. Үүнд:

Хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн 2 хүсэлт, гомдлыг хэлэлцэж, санал, зөвлөмж гаргаж эрх бүхий этгээдэд хүргүүлсэн.

2024 онд 30 удаа хуралдаж:

- 2 зөвлөмж
- 1 дүгнэлт
- 7 санал
- 2 хүсэлт
- 3 шаардлага

Нийт 15 албан бичгийг

- ТУЗ-д /10/
- Гүйцэтгэх захиралд /2/
- Сангийн Сайдад /2/
- СЗХ-д /1/ хүргүүлсэн.

Захиргаа, санхүүгийн газраас 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн гүйцэтгэлийн мэдээлэл, тайлбар, тодруулга авч компанийн 2024 оны тайланг дүгнэн хувьцаа эзэмшигчийн тэргүүн зорилго болох хөрөнгө оруулалтаас ашиг хүртэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой зохион байгуулах, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах зэрэг саналыг Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлж ажиллалаа.

Хяналтын зөвлөл жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөлтэй 2 удаа, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчтэй 1 удаа тус тус уулзалт зохион байгуулж компанийн засаглал үйл ажиллагааны ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх байдлаар санал солилцсон.

ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2024




ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД ТҮҮХЭН ДЭЭД ТҮВШИНД ХҮРЛЭЭ

"Монголын хөрөнгийн бирж" ХК 2024 онд нийт 250 удаагийн үнэт цаасны арилжаа зохион байгуулж, нийт 1 их наяд 406.12 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас арилжлаа.

Үүнд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 317.52 тэрбум төгрөг, өрийн хэрэгслийн арилжаа 896 тэрбум төгрөг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа 146.63 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа 10.89 тэрбум төгрөгт хүрсэн нь тус үнэт цаас бүрийн арилжааны хувьд түүхэн дээд үзүүлэлт боллоо.

Түүнчлэн 2024 онд үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр 13 их наяд 017 тэрбум төгрөг буюу түүхэн дээд түвшинд, мөн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр ТОП-20 индексо 51,296.39 нэгжид хүрсэн түүхэн дээд амжилтаар энэ оны арилжаа хаагдлаа.



ЗЭСИЙН БАЯЖМАЛ, ХАЙЛУУР ЖОНШ БИРЖЭЭР АНХ УДАА АРИЛЖИГДАЖ ЭХЛЭВ



Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 223 тоот тогтоолын дагуу Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нүүрс, төмөр, хайлуур жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнийг, 2024 оны 73 дугаар тогтоолоор зэсийн баяжмалыг арилжаалах шийдвэр гарсны дагуу анх удаа 2024 оны 4 дүгээр сард "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын зэсийн баяжмалыг, 2024 оны 6 дугаар сард "Монголросцветмет" ТӨҮГ-ын хайлуур жоншны баяжмалыг амжилттай арилжааллаа.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ БАТЛАГДАЖ, МХБ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨРГӨЖИН ТЭЛЭХ, ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД НЭВТРЭХ НӨХЦӨЛ БҮРДЭВ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр УИХ-ын хуралдаанаар эцэслэн баталсан.

Тус хуульд хувьцааны хамтын санхүүжилт, банкны хадгаламжийн сертификат гаргах, олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл, мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулсан хаалттай хувьцаат компанийн хувьцааг биржээр арилжаалах, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх зэрэг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой зохицуулалтууд тусгагдаж, үүний дагуу Монголын хөрөнгийн биржийн эрхлэх үйл ажиллагааны төрөл өргөжин тэлэх нөхцөл бүрдэв.



ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД АНХ УДАА ОРОН НУТГИЙН БОНД БҮРТГЭГДЭН, АМЖИЛТТАЙ АРИЛЖИГДЛАА

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 48 тоот тогтоолоор Нийслэлийн төсөвт тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор нийт 500 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх "Улаанбаатар бонд"-ыг олон нийтэд нээлттэй санал болгосон нь Монголын хөрөнгийн биржид бүртгэгдэн арилжаалагдсан орон нутгийн анхны бонд болж, хөрөнгийн зах зээлд түүхэн үйл явдал боллоо.



УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНД ОРОЛЦОГЧДЫН ТОО НЭМЭГДЛЭЭ



"Монголын хөрөнгийн бирж" ХК нь БНХАУ-ын Элчин сайдын яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын уул уурхайн үндэсний ассоциатай хамтран БНХАУ-ын Бээжин хотноо 2024 оны 5 дугаар сард "Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний биржийн өдөрлөг"-ийг зохион байгуулж 130 гаруй худалдан авагчдыг хамруулан уул уурхайн бүтээгдэхүүнийг арилжааг сурталчлах арга хэмжээг зохион байгууллаа.

2024 оны 4-р улирлын байдлаар МХБ-д бүртгэлтэй худалдан авагчдын тоо 414-т, уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд зуучлагч брокерын тоо 13-т тус тус хүрч, оролцогчдын тоо болон зах зээлийн хэмжээ тэлснээс гадна уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд худалдан авагчид брокероор дамжуулан оролцож эхлэв.

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК 7000 ГАРУЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭДЭЭ НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАВ

"Монголын хөрөнгийн бирж" ХК нь 2022 оны 12 сард IPO хийж, 34 хувиа олон нийтэд нээлттэй арилжиж, хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн нь хөрөнгийн зах зээлд жишиг IPO болсон билээ.

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Компанийн 2023 оны жилийн эцсийн аудитын өмнөх санхүүгийн тайлангийн татварын дараах цэвэр ашиг болох 8,699,165,845 төгрөгөөс нийт 4,349,252,518.99 төгрөг буюу нэгж хувьцаанд 12 төгрөг 41 мөнгөөр тооцож ногдол ашиг хуваариллаа.




ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ДЭЭР ХАМГИЙН ОЛОН НОГООН БОНДУУД АРИЛЖИГДСАН ТҮҮХЭН ҮЗҮҮЛЭЛТ ТОГТООВ

МХБ нь 2017 онд Тогтвортой хөрөнгийн биржийн санаачилгад элсэн орж, тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх талаар анхааран ажилласан бөгөөд 2018 онд ногоон, тогтвортой санхүүгийн хэрэгслүүдийг дэмжих зохицуулалтуудыг "Үнэт цаасны бүртгэлийн журам"-даа тусгасан.

2024 оны хувьд хөрөнгийн зах зээлд "Хаан банк" ХК болон "ТЖТБ" ХХК нь нийт 3 төрлийн 40 сая ам.долларын үнийн дүн бүхий ногоон бонд гаргаснаар хамгийн олон ногоон бонд арилжсан жил боллоо.



"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК ISO/IEC 27001:2023 / ISO/IEC 27001:2022 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЛЭЭ



"Монголын хөрөнгийн бирж" ХК нь уул уурхайн бүтээгдэхүүний биржийн болон үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаандаа Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн ISO/IEC 27001:2023 / ISO/IEC 27001:2022 стандартыг 2024 онд нэвтрүүлж, баталгаажуулалтын гэрчилгээг гардан авлаа.

Бирж эдгээр стандартын шаардлагыг хангах зорилгоор 2023 оноос бодлого, хамрах хүрээг тодорхойлох, суурь дүрэм журам боловсруулах, бусад шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн бөгөөд Кибер аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газраас баталсан "Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага"-ын хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлж, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласнаа тус стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА ӨРГӨЖИВ

Өнгөрсөн 2024 онд МХБ гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдад Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг сурталчлах чиглэлээр нэлээд ажлуудыг зохион байгууллаа.


Тухайлбал, дотоодын үнэт цаасны зах зээлийн өдөрлөгийг 2024 оны 4 сард АНУ-ын Нью-Йорк хотод, 2024 оны 11 сард Сингапур улсад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан бол уул уурхайн бүтээгдэхүүний биржийн талаарх сурталчилгааг БНХАУ, БНЭУ-д тус тус амжилттай зохион байгуулсан.

Түүнчлэн, МХБ нь 2024 онд Бээжингийн хөрөнгийн бирж, Шанхайн фьючерсийн бирж, Далианы таваарын бирж болон Истанбулын биржтэй хамтын ажиллагааг эхлүүлэв.



ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

	Үнэт цаасны төрөл	Олон нийтэд санал болгосон дүн /тэрбум/	Захиалгын дүн /тэрбум/	Захиалгын хувь	Хөрөнгө оруулагчдын тоо
“АРД КРЕДИТ ББСБ” ХК	Нэмэлт Хувьцаа	₮ 8.9	₮ 9.1	102%	1,578
“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК	Хувьцаа	₮ 15.2	₮ 15.3	100%	485
“ГРАНД СИСТЕМС” ХК	Хувьцаа	₮ 0.675	₮ 0.683	101%	132
“ТЭНГЭР ДААТГАЛ” ХК	Хувьцаа	₮ 10.00	₮ 10.90	109.07%	992
БЭРС-3	ХБУЦ	₮ 15.00	₮ 15.00	100%	71
БИЧИЛ-3	ХБУЦ	₮ 20.00	₮ 20.00	100%	90
“ИНВЕСКОР ББСБ” ХК	ХБУЦ	₮ 50.00	₮ 50.00	100%	119
“АШИД КАПИТАЛ ББСБ” ХХК	Бонд /транч 3/	₮ 20.0	₮ 20.0	100%	210
УЛААНБААТАР БОНД	Бонд /транч 1,2,3/	₮ 500.0	₮ 500.0	100%	15
“СЭНДЛИ ББСБ” ХК	Бонд /транч 2/	₮ 10.0	₮ 10.0	100%	185
НОГООН БОНД-2	Бонд	₮ 84.74	₮ 84.74	100%	2
GREEN RECYCLE BOND-1	Бонд	₮ 34.5	₮ 34.5	100%	148
ШУНХЛАЙ БОНД-2	Бонд	₮ 40.0	₮ 40.0	100%	2
ШУНХЛАЙ БОНД-1	Бонд	₮ 40.0	₮ 40.0	100%	149



ШУНХЛАЙ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

₮ 12.99

ИХ НАЯД

+11.82%

+₮ 1.37

ИХ НАЯД

ТОП-20 ИНДЕКС

51 296.39

НЭГЖ

+23.79%

+9,859

НЭГЖ

MSE A ИНДЕКС

19 795.97

НЭГЖ

+12.64%

+2,221

НЭГЖ

MSE B ИНДЕКС

15 197.38

НЭГЖ

+34.17%

+3,870

НЭГЖ

ТОП-20 ИНДЕКСИЙН САГС



"Монголын хөрөнгийн бирж" ХК Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журмын дагуу үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП-20 индексийн сагсыг 2024 онд дараах компаниуд бүрдүүлж байв.

	СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	
1	KHAN	"ХААН БАНК" ХК	 ХААН БАНК
2	TDB	"ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК" ХК	 TDB TRADE & DEVELOPMENT BANK
3	APU	"АПУ" ХК	 APU COMPANY Absolute. Pure. Unique.
4	INV	"ИНВЕСКОР ББСБ" ХК	 InvesCore
5	GLMT	"ГОЛОМТ БАНК" ХК	 ГОЛОМТ БАНК Саяаг сонирхонг сонирхууриаралт
6	TTL	"ТАВАН ТОЛГОЙ" ХК	 ТАВАН ТОЛГОЙ ХК
7	GOV	"ГОВЬ" ХК	 GOBI MONGOLIAN CASHMERE
8	CUMN	"ПРЕМИУМ НЭКСУС" ХК	 
9	BOGD	"БОГД БАНК" ХК	 БОГД БАНК ИГЭЭЛ ТИЭЭНЭ
10	SBM	"ТӨРИЙН БАНК" ХК	 ТӨРИЙН БАНК
11	MSE	"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК	 МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
12	TUM	"ТҮМЭН ШУВУУТ" ХК	 ТҮМЭН ШУВУУТ ШУУ, ТӨӨРӨГӨЙ, ХӨӨГӨЙ, ХӨӨГӨЙ, ХӨӨГӨЙ
13	SUU	"СҮҮ" ХК	 МОНГОЛ ХӨӨН УУТАН ҮЙЛДВЭР COTI Хүндэтгэсэн
14	MNP	"МОНГОЛ ШУУДАН" ХК	 МОНГОЛ ШУУДАН
15	MLG	"МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ" ХК	 monlogistics HOLDING
16	SEND	"СЭНДЛИ БСББ" ХК	 Sendly
17	MNDL	"МАНДАЛ ДААТГАЛ" ХК	 МАНДАЛ ДААТГАЛ
18	MFC	"МОНОС ХҮНС" ХК	 МОНОС ХҮНС
19	ADB	"АРД КРЕДИТ ББСБ" ХК	 КРЕДИТ ББСБ
20	GAZR	"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХК	 ГАЗАР ШИМ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

ХУВЬЦААНЫ БҮРТГЭЛ


"Монголын хөрөнгийн бирж" ХК-д 2025 оны 02 сарын 12-ны байдлаар 172 ХК бүртгэлтэй байгаагаас 2.3% буюу 4 ХК нь 100 хувь төрийн өмчит, 6.4% буюу 11 ХК нь төрийн өмчийн оролцоотой, 91.27% нь буюу 157 ХК нь бүрэн хувьчлагдсан компани байна.

Барилга	18
Боловсруулах үйлдвэрлэл	43
Бөөний болон жижиглэн худалдаа	4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	4
Мэдээлэл, холбоо	8
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	30
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	11
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	8
Уул уурхай, олборлолт	3
Ус хангамж	16
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	18
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2
НИЙТ	172


Бүртгэлтэй үнэт цаасны хувьд нийт 19,907,859,922 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас 6.75 % буюу 1,343,420,405 тэрбум ширхэг нь төрийн мэдэлд, 18,564,439,517 тэрбум ширхэг буюу 93.25% нь хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДИКАТОРУУД

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжаалагдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 12 их наяд 993.66 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1,373.42 тэрбум төгрөг буюу 11.82 хувиар өссөн үзүүлэлтэй гарчээ.



Тайлант хугацаанд TOP-20 индексийн дээд үзүүлэлт 51 296.39 нэгж, доод үзүүлэлт 40 704.45 нэгж, дундаж үзүүлэлт 45 889.91 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 858.97 нэгжээр буюу 23.79 хувиар өсөж, 51 296.39 нэгж болсон байна.




Тайлант хугацаанд MSE-A индексийн дээд үзүүлэлт 19 842.43 нэгж, доод үзүүлэлт 16 294.41 нэгж, дундаж үзүүлэлт 17 932.79 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 221.44 нэгжээр буюу 12.64 хувиар өсөж, 19 795.97 нэгж болсон бол MSE-B индексийн дээд үзүүлэлт 15 444.11 нэгж, доод үзүүлэлт 11 321.67 нэгж, дундаж үзүүлэлт 13 503.28 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 870.24 нэгжээр буюу 34.17 хувиар өсөж, 15 197.38 нэгж болсон байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

2024 онд нийт 250 удаагийн үнэт цаасны арилжаа явагдаж, хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 145 ХК-ийн 352.33 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1 тэрбум 125.56 сая ширхэг хувьцааг, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 146.63 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1.63 сая ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 10.89 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 16.41 сая ширхэг нэгж эрхийг, өрийн хэрэгслийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 896.25 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 8.05 сая ширхэг өрийн хэрэгслийг тус тус арилжиж, нийт 1 их наяд 406.12 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1 тэрбум 406.12 сая ширхэг үнэт цаас арилжигдсан.




Нийт арилжааны үнийн дүнгийн 25.06 хувь буюу 352.33 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 10.43 хувь буюу 146.63 тэрбум төгрөгийг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны арилжаа, 0.78 хувь буюу 10.89 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа, 63.74 хувь буюу 896.25 тэрбум төгрөгийг өрийн хэрэгслийн арилжаа тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 5.62 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 4.60 сая ширхэг үнэт цаас арилжсан байна. Нийт арилжааны үнийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн байна.

ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Тайлант хугацаанд нийт 250 удаагийн арилжаагаар 145 ХК-ийн 352.33 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1 тэрбум 125.56 сая ширхэг хувьцаа арилжигдсанаас 9.88 хувь буюу 34.81 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 90.12 хувь буюу 317.52 тэрбум төгрөгийн гүйлгээг хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзэлж байна.

ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ



ХУВЬЦААНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Тайлант хугацаанд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 317.52 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 940.75 сая ширхэг хувьцаа арилжсан байна. Нийт 145 ХК-ийн үнэт цаас арилжигдсанаас 104 компанийн үнэт цаасны ханш өсөж, 37 компанийн үнэт цаасны ханш буурч, 4 компанийн үнэт цаасны ханш тогтмол арилжигдсан байна.

ХУВЬЦААНЫ БАГЦЫН АРИЛЖАА

Тайлант хугацаанд 120.82 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 285.10 сая ширхэг хувьцааг багцын арилжаагаар арилжсан байна. Энэ нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн дүнгийн 38.05 хувийг эзэлж байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

ХУВЬЦААНЫ ТЕНДЕР САНАЛЫН АРИЛЖАА

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн дагуу биржид бүртгэлтэй үнэт цаасыг худалдан авах санал гаргадаг. Тайлант хугацаанд нийт 4 хувьцаат компанийн 3.51 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 12.62 сая ширхэг хувьцааг тендер саналын арилжаагаар арилжсан байна.

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

Тайлант хугацаанд анхдагч зах зээлд 85.00 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 850.00 мянган ширхэг, хоёрдогч зах зээлд 25.38 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 377.25 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас арилжсан байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН АРИЛЖАА

Тайлант хугацаанд "Үндэсний хувьчлалын сан" болон "Мандал ирээдүйн өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 10.89 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 16.41 сая ширхэг нэгж эрхийг арилжсан байна. Үүнээс "Мандал ирээдүйн өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн 1.16 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1.07 сая ширхэг нэгж эрхийг багцын арилжаагаар арилжсан.

ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

Өрийн хэрэгслийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 896.25 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 8.05 сая ширхэг өрийн хэрэгсэл арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 63.74 хувийг эзэлж байна.

БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУД

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар I ангилалд 27, II ангилалд 49, III ангилалд 96 хувьцаат компани багтаж байна.



ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН 30 ХУВЬЦАА

ҮНЭТ ЦААС	ШИРХЭГ /сая/		ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН /тэрбум/
ГОВЬ	282	1	ГОВЬ	72
БОГД БАНК	88.6	2	ХААН БАНК	39.1
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ	73.4	3	ИНВЕСКОР ББСБ	35.6
ПРЕМИУМ НЭКСУС	54	4	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	20.3
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	45.6	5	ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ	14.7
АРД КРЕДИТ ББСБ	44.7	6	АПУ	12.5
СЭНДЛИ БСББ	42.3	7	ГОЛОМТ БАНК	11.9
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	38.6	8	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	10.6
ХААН БАНК	36.6	9	ПРЕМИУМ НЭКСУС	9.8
ЛЭНДМН ББСБ	29	10	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	7.9
МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	23.8	11	СЭНДЛИ БСББ	7.8
Э-ТРАНС ЛОЖИСТИКС	22.5	12	БОГД БАНК	7.5
МАНДАЛ ДААТГАЛ	21.6	13	ТАВАН ТОЛГОЙ	7.4
ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС	17.5	14	ХАС БАНК	6.9
АПУ	12.3	15	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	6.7
МОНОС ХҮНС	11.5	16	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	4.8
ГОЛОМТ БАНК	10.2	17	АРД КРЕДИТ ББСБ	4.6
ХАС БАНК	9.6	18	ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП	3.4
АЙТҮҮЛС	9	19	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	3
ДАРХАН НЭХИЙ	7.6	20	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	3
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	6.5	21	ЛЭНДМН ББСБ ХК	2.7
ТҮМЭН ШУВУУТ	5.9	22	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	2.7
ЭМ ЖИ ЭЛ АКУА	5.3	23	УЛААНБААТАР ХИВС	2.5
ИНВЕСКОР ББСБ	4.7	24	ТӨРИЙН БАНК	2.3
ТӨРИЙН БАНК	4.6	25	ТҮМЭН ШУВУУТ	2.1
РЕМИКОН	3.9	26	МОНГОЛ ШУУДАН	1.8
БОДЬ ДААТГАЛ	3.1	27	МАНДАЛ ДААТГАЛ	1.7
МОНГОЛ ШУУДАН	2.6	28	АРД ДААТГАЛ	1.4
ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	2.4	29	МОНОС ХҮНС	1
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	2.4	30	ЭРДЭНЭТ ХҮНС	0.9

ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ 20 ҮНЭТ ЦААС

	ҮНЭТ ЦААС	ХААЛТЫН ХАНШ		ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ	
		2024.12.31	2023.12.28	/Үнийн дүн/	/Хувь/
1	МОНГОЛ КЕРАМИК	14,000	2,248	11,752 ▲	522.78
2	ХАРХОРИН	7,300	1,360	5,940 ▲	436.76
3	НАКО ТҮЛШ	81.00	20.53	60.47 ▲	294.54
4	СОР	2,700	709	1,991 ▲	280.82
5	ХОРИН ХОЁРДУГААР БААЗ	4,323	1,400	2,923 ▲	208.79
6	ХҮННҮ МЕНЕЖМЕНТ	4,250	1,380	2,870 ▲	207.97
7	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	354.04	116.97	237.07 ▲	202.68
8	ЛЭНДМН ББСБ	153.00	53.96	99.04 ▲	183.54
9	БАЯНТЭЭГ	59,500	23,000	36,500 ▲	158.70
10	УЛААНСАН	9,400	3,737	5,663 ▲	151.54
11	МОННООС	44,880	18,050	26,830 ▲	148.64
12	ШАРЫН ГОЛ	1,550	649.14	900.86 ▲	138.78
13	МОНГОЛ НЭХМЭЛ	23,000	10,120	12,880 ▲	127.27
14	ЖЕНКО ТУР БҮРО	61	29.26	31.74 ▲	108.48
15	МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	3,236	1,610	1,626 ▲	100.99
16	ТАВАН ТОЛГОЙ	34,020	17,810	16,210 ▲	91.02
17	БАГАНУУР	1,499	788	711 ▲	90.23
18	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	1,556	848.04	707.96 ▲	83.48
19	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	190	105	85 ▲	80.95
20	ТЭЭВЭР ДАРХАН	26,500	14,990	11,510 ▲	76.78

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ 20 ҮНЭТ ЦААС

	ҮНЭТ ЦААС	ХААЛТЫН ХАНШ		ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ	
		2024.12.31	2023.12.28	/Үнийн дүн/	/Хувь/
1	ӨНДӨРХААН	13,000	24,100	(11,100)	▼ (46.06)
2	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	59.00	100.00	(41.00)	▼ (41.00)
3	ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП	5,990	10,000	(4,010)	▼ (40.10)
4	БЭРХ УУЛ	1,203	2,000	(797)	▼ (39.85)
5	БОДЬ ДААТГАЛ	88.81	119.92	(31.11)	▼ (25.94)
6	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	25,180	33,500	(8,320)	▼ (24.84)
7	МИК ХОЛДИНГ	16,570	22,000	(5,430)	▼ (24.68)
8	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГ	735	971	(236)	▼ (24.30)
9	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	2,701	3,506	(805)	▼ (22.96)
10	АДУУН ЧУЛУУН	480	620	(140)	▼ (22.58)
11	МОНГОЛ САВХИ	819	1,000	(181)	▼ (18.10)
12	АПУ	1,001	1,211	(210)	▼ (17.34)
13	ГАН ХИЙЦ	5,575	6,500	(925)	▼ (14.23)
14	МОНГОЛ ДААТГАЛ	2,500	2,900	(400)	▼ (13.79)
15	МОНОС ХҮНС	88.89	99.95	(11.06)	▼ (11.07)
16	ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ	215.06	236.56	(21.50)	▼ (9.09)
17	ТӨРИЙН БАНК	509.35	559.05	(49.70)	▼ (8.89)
18	АРД ДААТГАЛ	800.51	874.53	(74.02)	▼ (8.46)
19	АВТО ИМПЕКС	1,437	1,552	(115)	▼ (7.41)
20	УВС ЧАЦАРГАНА	425	459.01	(34.01)	▼ (7.41)

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ ТОЙМ


2024 ОНД МХБ-ЭЭР АРИЛЖИГДСАН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ ТОЙМ

"Монголын Хөрөнгийн Бирж" ХК нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор батлагдсан "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-ын хүрээнд нүүрсний арилжаанд оролцогч талууд болох нүүрс худалдах болон худалдан авах сонирхол бүхий этгээдүүдийг оролцуулсан туршилтын цахим дуудлага арилжааг 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан.

Уул уурхайн бүтээгдэхүүний цахим дуудлага арилжааг нээлттэй, ил тод, шударга зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтох боломжийг бүрдүүлснээр 2024 онд худалдагч компаниуд болох "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Энержи Ресурс" ХХК, "Хангад Эксплорэйшн" ХХК, "Тавантолгой" ХК, "Андын Илч" ХХК, "Монголросцветмет" ТӨҮГ, "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК, "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, "Премиумкөул Корпораци" ХХК, "Монголын Алт" ХХК, "Өсөх Зоос" ХХК, "Очир мандал хайрхан" ХХК, "Мөнх тэнүүн оргил" ХХК, "Саусгоби Даймонд" ХХК, "Эрд Гео" ХХК нь "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-иар дамжуулан нийт 817 удаагийн дуудлага арилжаагаар 24.8 сая тонн нүүрс, төмөр, жонш, зэс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнүүдийг 8.89 их наяд төгрөгөөр буюу 2.6 тэрбум ам.доллараар арилжаалсан байна.

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖАА

2024 онд нийт 571 удаагийн уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа амжилттай явагдаж 24,817,115 тонн уул уурхайн бүтээгдэхүүн арилжигдсан бөгөөд нүүрсний арилжаагаар 22,368,000 тонн нүүрс, төмрийн арилжаагаар 2,425,500 тонн төмрийн хүдэр болон баяжмал, хайлуур жоншны арилжаагаар 17,615 тонн хайлуур жоншны хүдэр болон баяжмал, зэсийн арилжаагаар 6,000 нойтон метр тонн зэсийн баяжмал тус тус арилжигдсан байна. Нийт арилжааны 90.1 хувийг нүүрсний арилжаа, 9.8 хувийг төмрийн арилжаа, 0.07 хувийг хайлуур жоншны арилжаа үлдсэн хувийг зэсийн баяжмалын арилжаа тус тус эзэлж байна.



НҮҮРСНИЙ АРИЛЖАА

2024 онд нийт 312 удаагийн нүүрсний дуудлага арилжаа амжилттай зохион байгуулагдаж 22.4 сая тонн нүүрсийг 8 их наяд 276.0 тэрбум төгрөгөөр буюу 2.44 тэрбум ам.доллараар арилжсан байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаагаар нүүрс арилжсан худалдагч компаниуд нь 2024 оны дуудлага арилжааны үеийн үнийн өсөлтөөс нийт 769.11 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна. Тайлант хугацаанд 1 удаагийн нүүрсний арилжаагаар дунджаар 71.7 мянган тонн нүүрсийг 26.5 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжээ /тонн/	Үнийн дүн /тэрбум/
1	1/3 коксжих нүүрс	9,132,800	₮ 3,134.4
2	Дэгдэмхий бодис дунд коксжих нүүрс	4,601,600	₮ 2,423.37
3	Эрчим хүчний нүүрс	3,328,000	₮ 611.03
4	Баяжуулсан коксжих нүүрс	2,585,600	₮ 1,489.46
5	Баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс	2,028,800	₮ 448.76
6	Чийг багатай хүрэн нүүрс	275,200	₮ 24.14
7	Дэгдэмхий бодис дундаас их хийн нүүрсний	256,000	₮ 77.77
8	Баяжуулсан сул коксжих нүүрс	140,800	₮ 62.53
9	Дэгдэмхий бодис их хийн нүүрсний	12,800	₮ 3.027
10	Баяжуулсан дунд зэрэг үнслэгтэй, сул коксжих нүүрс	6,400	₮ 1.53
	НИЙТ	22,368,000	₮ 8,276.04


Нийт нүүрсний арилжааны үнийн дүнгийн 37.87 хувь буюу 3 их наяд 134.41 тэрбум төгрөгийг 1/3 коксжих нүүрсний арилжаа, 29.28 хувь буюу 2 их наяд 423.38 тэрбум төгрөгийг дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрсний арилжаа, 18.0 хувь буюу 1 их наяд 489.46 тэрбум төгрөгийг баяжуулсан коксжих нүүрсний арилжаа, 7.38 хувь буюу 611.03 тэрбум төгрөгийг эрчим хүчний нүүрсний арилжаа, 5.42 хувь буюу 448.76 тэрбум төгрөгийг баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрсний арилжаа, 0.94 хувь буюу 77.78 тэрбум төгрөгийг дэгдэмхий бодис дундаас их хийн нүүрсний арилжаа, 0.76 хувь буюу 62.53 тэрбум төгрөгийг баяжуулсан сул коксжих нүүрсний арилжаа, 0.29 хувь буюу 24.14 тэрбум төгрөгийг чийг багатай хүрэн нүүрсний арилжаа, 0.04 хувь буюу 3.03 тэрбум төгрөгийг дэгдэмхий бодис их хийн нүүрсний арилжаа, 0.02 хувь буюу 1.53 тэрбум төгрөгийг баяжуулсан дунд зэрэг үнслэгтэй, сул коксжих нүүрсний арилжаа тус тус эзэлж байна.

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ ТОЙМ

Нийт нүүрсний арилжааны үнийн дүнд эзлэх хувь



Нүүрсний арилжааны нийт үнийн дүнгийн 64.34 хувь буюу 5 их наяд 324.86 тэрбум төгрөгийн арилжааг "Эрдэнэс Тавантолгой" ХК, 23.31 хувь буюу 1 их наяд 928.83 тэрбум төгрөгийн арилжааг "Энержи Ресурс" ХХК, 11.08 хувь буюу 917.11 тэрбум төгрөгийн арилжааг "Тавантолгой" ХК, 0.76 хувь буюу 62.53 тэрбум төгрөгийн арилжааг "Хангад Эксплорэйшн" ХХК, 0.19 хувь буюу 15.97 тэрбум төгрөгийн арилжааг "Андын илч" ХХК, 0.14 хувь буюу 11.74 тэрбум төгрөгийн арилжааг "Монголын Алт (МАК)" ХХК, 0.1 хувь буюу 8.17 тэрбум төгрөгийн арилжааг "Премиумкөүл Корпораци" ХХК, 0.04 хувь буюу 3.03 тэрбум төгрөгийн арилжааг "Өсөх зоос" ХХК, 0.03 хувь буюу 2.27 тэрбум төгрөгийн арилжааг "Мөнх тэнүүн оргил" ХХК, 0.02 хувь буюу 1.53 тэрбум төгрөгийн арилжааг "Саусгоби Даймонд" ХХК тус тус арилжаалсан байна.



НҮҮРСНИЙ АРИЛЖАА

2024 онд нийт 312 нүүрсний арилжаа амжилттай зохион байгуулагдсан бөгөөд 5 дугаар сард хамгийн их буюу 55 удаагийн нүүрсний арилжаа хийгдсэн байна. Үүнд:

1 дүгээр сард нийт 22 удаагийн нүүрсний арилжаа явагдаж **1,504,000 тонн** буюу **626.53 тэрбум** төгрөгийн арилжаа,

2 дугаар сард нийт 24 удаагийн нүүрсний арилжаа явагдаж **2,438,400 тонн** буюу **1 их наяд 231.56 тэрбум** төгрөгийн арилжаа,

3 дугаар сард нийт 22 удаагийн нүүрсний арилжаа явагдаж **1,280,000 тонн** буюу **535.04 тэрбум** төгрөгийн арилжаа,

4 дүгээр сард нийт 34 удаагийн нүүрсний арилжаа явагдаж **4,185,600 тонн** буюу **1 их наяд 724.8 тэрбум** төгрөгийн арилжаа,

5 дугаар сард нийт 55 удаагийн нүүрсний арилжаа явагдаж **3,923,200 тонн** буюу **1 их наяд 382.43 тэрбум** төгрөгийн арилжаа,

6 дугаар сард нийт 31 удаагийн нүүрсний арилжаа явагдаж **1,222,400 тонн** буюу **367.17 тэрбум** төгрөгийн арилжаа,

7 дугаар сард нийт 27 удаагийн нүүрсний арилжаа явагдаж **1,593,600 тонн** буюу **637.56 тэрбум** төгрөгийн арилжаа,

8 дугаар сард нийт 20 удаагийн нүүрсний арилжаа явагдаж **864,000 тонн** буюу **221.95 тэрбум** төгрөгийн арилжаа,

9 дүгээр сард нийт 12 удаагийн нүүрсний арилжаа явагдаж **787,200 тонн** буюу **239.29 тэрбум** төгрөгийн арилжаа,

10 дугаар сард нийт 41 удаагийн нүүрсний арилжаа явагдаж **2,054,400 тонн** буюу **700.08 тэрбум** төгрөгийн арилжаа,

11 дүгээр сард нийт 20 удаагийн нүүрсний арилжаа явагдаж **1,862,400 тонн** буюу **470.49 тэрбум** төгрөгийн арилжаа,


12 дугаар сард нийт 4 удаагийн нүүрсний арилжаа явагдаж **652,800 тонн** буюу **139.13 тэрбум** төгрөгийн арилжаа тус тус амжилттай арилжаалагдсан.

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ ТОЙМ

ТӨМРИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛЫН АРИЛЖАА


2024 онд нийт 250 удаагийн төмрийн дуудлага арилжаа амжилттай арилжигдаж 2.4 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 567.8 тэрбум төгрөгөөр буюу 167.53 сая ам.доллароор арилжсан байна. Төмрийн хүдэр, баяжмалын дуудлага арилжааны дундаж өсөлт нь 4.1% ы, төмрийн арилжааны үеийн үнийн өсөлтөөс худалдагч компаниуд нь 26.98 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна. Тайлант хугацаанд 1 удаагийн төмрийн арилжаагаар дунджаар 9.7 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 2.3 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

2024 онд арилжигдсан төмрийн хүдэр, баяжмал.



2024 онд нийт 250 удаагийн арилжаагаар 2.4 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 567.8 тэрбум төгрөгөөр арилжсан. Үүнд:

2024 онд арилжигдсан төмрийн хүдэр, баяжмал.
/тонн/



1,598,550 тонн буюу 376.17 тэрбум төгрөгийн төмрийн баяжмал, 826,950 тонн буюу 191.59 тэрбум төгрөгийн төмрийн хүдэр тус тус арилжигдсан байна. Тодруулбал: Fe – 65%-ийн төмрийн баяжмал 320,100 тонн буюу 99.03 тэрбум төгрөгийн, Fe – 58%-ийн төмрийн баяжмал 1,278,450 тонн буюу 277.14 тэрбум төгрөгийн, Fe-52%-ийн төмрийн хүдэр 826,950 тонн буюу 191.59 тэрбум төгрөгийн арилжаа тус тус зохион байгуулагдсан байна. Үүнд:

1 дүгээр сард 16 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж **102,000 тонн** буюу **30.11 тэрбум** төгрөгийн арилжаа,

2 дугаар сард 32 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж **200,700 тонн** буюу **50.2 тэрбум** төгрөгийн арилжаа,

3 дугаар сард 11 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж **56,100 тонн** буюу **14.64 тэрбум** төгрөгийн арилжаа,

4 дүгээр сард 23 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж **175,800 тонн** буюу **39.74 тэрбум** төгрөгийн арилжаа,

5 дугаар сард 37 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж **278,400 тонн** буюу **68.15 тэрбум** төгрөгийн арилжаа,

6 дугаар сард 29 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж **167,100 тонн** буюу **39.07 тэрбум** төгрөгийн арилжаа,

7 дугаар сард 16 удаагийн төмрийн хүдэр баяжмалын арилжаа явагдаж **52,800 тонн** буюу **12.8 тэрбум** төгрөгийн арилжаа,

8 дугаар сард 16 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж **402,600 тонн** буюу **91.71 тэрбум** төгрөгийн арилжаа,


9 дүгээр сард 18 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж **343,200 тонн** буюу **77.21 тэрбум** төгрөгийн арилжаа,

10 дугаар сард 15 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж **231,000 тонн** буюу **53.52 тэрбум** төгрөгийн арилжаа,

11 дүгээр сард 26 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж **244,200 тонн** буюу **54.57 тэрбум** төгрөгийн арилжаа,

12 дугаар сард 11 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж **171,600 тонн** буюу **36.04 тэрбум** төгрөгийн арилжаа тус тус зохион байгуулагдсан.

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ ТОЙМ



Нийт төмрийн арилжааны үнийн дүнд эзлэх хувь
/худалдагч компаниуд/

2024 онд "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК нь нийт 1.38 сая тонн Fe-52%-ийн төмрийн хүдэр болон Fe-58%-ийн төмрийн баяжмалыг 296.67 тэрбум төгрөгөөр, "Монголросцветмет" ТӨҮГ нь нийт 1.05 сая тонн Fe-52%-ийн төмрийн хүдэр болон Fe-65%-ийн төмрийн баяжмалыг 271.09 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан байна.

ЗЭСИЙН БАЯЖМАЛЫН АРИЛЖАА

2024 онд нийт 2 удаагийн арилжаагаар 6.0 мянган нойтон метр тонн зэсийн баяжмалыг 40.5 тэрбум төгрөгөөр арилжаалав. Үүнд:

4 дүгээр сард 1 удаагийн зэсийн баяжмалын арилжаагаар 3,000 нойтон метр тонн буюу 19.66 тэрбум төгрөгийн арилжаа,

5 дугаар сард 1 удаагийн зэсийн баяжмалын арилжаагаар 3,000 нойтон метр тонн буюу 20.84 тэрбум төгрөгийн арилжаа амжилттай хийгдсэн байна.

Тайлант хугацаанд "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ нь 6.0 мянган НМТ 22.35%-ийн зэсийн агуулгатай баяжмалыг 40.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.

ХАЙЛУУР ЖОНШНЫ АРИЛЖАА


2024 онд нийт 7 удаагийн арилжаагаар 17.6 мянган тонн хайлуур жоншны хүдэр, баяжмалыг 9.98 тэрбум төгрөгөөр арилжаалав. Үүнд:

6 дугаар сард 1 удаагийн хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжаагаар 4,355 тонн буюу 5.3 тэрбум төгрөгийн арилжаа,

8 дугаар сард 2 удаагийн хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжаагаар 7,800 тонн буюу 2.0 тэрбум төгрөгийн арилжаа,

9 дүгээр сард 1 удаагийн хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжаагаар 3,250 тонн буюу 778.3 сая төгрөгийн арилжаа,

11 дүгээр сард 3 удаагийн хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжаагаар 2,210 тонн буюу 1.85 тэрбум төгрөгийн арилжаа зохион байгуулагдсан байна.




Нийт жоншны арилжааны үнийн дүнд эзлэх хувь
/худалдагч компаниуд/


2024 онд "Монголросцветмет" ТӨҮГ нь нийт 4.49 мянган тонн CaF₂-78%-ийн бүхэллэг хайлуур жонш болон CaF₂-95%-ийн хайлуур жоншны баяжмалыг 5.4 тэрбум төгрөгөөр, "Очир мандал хайрхан" ХХК нь нийт 8.58 мянган тонн CaF₂-78%, CaF₂-85%-ийн бүхэллэг хайлуур жонш болон CaF₂ < 42%-ийн хайлуур жоншны хүдрийг 3.44 тэрбум төгрөгөөр, "Эрд гео" ХХК нь 4.6 мянган тонн CaF₂ < 42%, CaF₂ 55%-63% хайлуур жоншийг 1.15 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан байна.

2024 ОНЫ САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Нийт орлого



Нийт зардал




Үнэт цаасны арилжааны шимтгэл




Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны шимтгэл




Төсөвт төлсөн татвар, шимтгэл




Зардал, орлогын харьцаа



Татварын дараах цэвэр ашиг



Хуримтлагдсан ашиг



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2024





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:СНАГ-2025/06/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamj@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Нямцэцэг
Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn
Грант торнтон аудит ХХК-ийн Ерөнхий захирал: Б.Осоргарав
Утас: 99113795 Цахим хаяг: info@mn.gt.com

Улаанбаатар хот
2025 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ"
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ДӨЛГӨӨН ТАНАА

2025.03.17 № 07/1070
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд аж ахуйн нэгж болон хуулийн этгээдүүд нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцохоор журмын дагуу нийт 767,771.2 сая төгрөгийн дэнчинг байршуулснаас арилжаанд ялсан 726,657.0 сая төгрөгийн битүүмжлэгдсэн дэнчин, 41,114.2 сая төгрөгийн идэвхтэй дэнчин "Монголын Хөрөнгийн Бирж ХК"-ийн харилцах дансанд байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд нийт орлогыг 37,076.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 9,840.1 сая төгрөгөөр баталж, 2,703.1 сая төгрөгийн татварын зардал тооцож, 24,328.1 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 46,661.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 8,586.1 сая төгрөг зарцуулж, орлогын албан татварын зардалд 3,799.1 сая төгрөгийг тайлагнаж, 34,176.6 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажилласан байна.

Z:\Yawsan_Bichig\2025\0317 SNAG-56.Docx

1525071234

Бусад асуудлын хэсэг

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 9-ны өдрийн 19 дугаар тогтоолоор компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг "Хангалттай" гэж дүгнэсэн байна. 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын хянаж баталгаажуулсан Компанийн 2023 оны засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлангийн дүгнэлт нь 100.0 хувь, хэвийн буюу эрсдэлгүй гэж заасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

“Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	902,582,814,516.91	816,117,554,232.94
1.1.2	Дансны авлага	1,868,454,950.77	936,933,524.46
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,457,509.01	34,072,853.11
1.1.4	Бусад авлага	149,471,451.41	2,148,534,565.92
1.1.6	Бараа материал	36,053,729.65	47,311,807.77
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	204,642,999.30	30,693,452.28
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	904,842,895,157.05	819,315,100,436.48
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,453,061,929.98	7,328,148,183.23
1.2.2	Биет бус хөрөнгө	16,998,953,543.12	17,044,540,713.61
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	22,452,015,473.10	24,372,688,896.84
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	927,294,910,630.15	843,687,789,333.32
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	265,821,383.36	91,733,714.37
2.1.1.2	Цалингийн өглөг	612,117.37	5,815,835.99
2.1.1.3	Татварын өглөг	341,303,910.22	235,985,175.46
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	17,955,656.95	109,442,220.57
2.1.1.12	УУБ-ны арилжааны дэнчинд байршиж буй мөнгө	880,962,845,181.82	767,771,156,772.44
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	881,588,538,249.72	768,214,133,718.83
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	635,862,600.00	635,862,600.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	990,698,992.92	928,380,130.26
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,626,561,592.92	1,564,242,730.26
2.2	Өр төлбөрийн нийт дүн	883,215,099,842.64	769,778,376,449.09
2.3	Эздийн өмч	35,046,353,900.00	35,046,353,900.00
2.3.1	а) төрийн	23,130,593,600.00	23,130,593,600.00
2.3.3	в) хувьцаат	11,915,760,300.00	11,915,760,300.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,021,146,332.29	20,005,435,662.81
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	446,321,902.02
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(11,434,011,346.80)	18,411,301,419.40
2.3.11	Эздийн өмчийн дүн	44,079,810,787.51	73,909,412,884.23
2.4	ӨР ТӨЛБӨР ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	927,294,910,630.15	843,687,789,333.32

“Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	12,147,031,303.89	13,521,664,119.64
2	Борлуулалтын өртөг	-	5,166,647,083.45
3	Нийт ашиг	12,147,031,303.89	8,355,017,036.19
5	Хүүний орлого	4,562,440,335.78	33,116,453,514.06
8	Бусад орлого	13,170,675.00	23,649,812.00
9	Борлуулалт маркетингийн зардал	186,062,107.06	671,207,509.55
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,992,598,429.63	2,624,904,971.74
12	Бусад зардал	19,748,469.36	123,399,481.77
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	(186,717,492.52)	(99,547,103.77)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	(196,590.99)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг	10,337,515,816.10	37,975,864,704.43
19	Орлогын татварын зардал	1,029,799,778.87	3,799,182,441.16
20	Татварын дараах ашиг	9,307,716,037.23	34,176,682,263.27
22	Тайлант үеийн цэвэр ашиг	9,307,716,037.23	34,176,682,263.27
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз /гарз/	-	-
24	Орлогын нийт дүн	9,307,716,037.23	34,176,682,263.27

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусаад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	23,130,593,600.00	20,021,146,332.29	446,321,902.02	(20,105,864,784.03)	23,492,197,050.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(635,862,600.00)	(635,862,600.00)
Залруулсан үлдэгдэл	23,130,593,600.00	20,021,146,332.29	446,321,902.02	(20,741,727,384.03)	22,856,334,450.28
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	9,307,716,037.23	9,307,716,037.23
Өмчид гарсан өөрчлөлт	11,915,760,300.00	-	-	-	11,915,760,300.00
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	35,046,353,900.00	20,021,146,332.29	446,321,902.02	(11,434,011,346.80)	44,079,810,787.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	38,117.87	38,117.87
Залруулсан үлдэгдэл	35,046,353,900.00	20,021,146,332.29	446,321,902.02	(11,433,973,228.93)	44,079,848,905.38
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	34,176,682,263.27	34,176,682,263.27
Зарласан ногдол ашиг	-	-	-	4,349,252,518.99	4,349,252,518.99
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(15,710,669.48)	-	17,844,904.05	2,134,234.57
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	35,046,353,900.00	20,005,435,662.81	446,321,902.02	18,411,301,419.40	73,909,412,884.23

СНАГ-2025/006/НА-СТА-ТӨҮГ

“Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	1,441,824,632,647.89	2,326,735,166,461.15
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	11,595,182,149.63	15,877,265,204.60
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	6,128,434.00	14,355,955.00
1.1.7	Хүлээн авсан хүүний орлого	4,413,827,379.90	31,119,193,464.18
1.1.9	Бусад мөнгөн орлого	1,425,809,494,684.36	2,279,724,351,837.37
1.2	Мөнгөн зарлагын дүн	544,905,224,391.89	2,410,500,737,760.85
1.2.1	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	238,000,000.00	-
1.2.2	Ажиллагчдад төлсөн	1,778,266,221.02	2,914,157,156.16
1.2.3	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	512,421,844.47	826,171,873.76
1.2.4	Бараа материал худалдан авахад төлсөн	41,110,050.00	63,964,460.50
1.2.5	Ашиглалтын зардалд төлсөн	111,522,685.60	85,682,299.14
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,758,400.00	991,960.00
1.2.8	Татварын байгууллагад төлсөн	2,058,142,678.97	5,486,589,832.72
1.2.9	Даатгалын төлбөрт төлсөн	5,000,000.00	5,106,920.00
1.2.10	Зохицуулалтын хөлс, шимтгэл хураамжид төлсөн	566,128,324.18	806,790,916.87
1.2.11	Бусад мөнгөн зарлага	539,592,874,187.65	2,400,311,282,341.70
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	896,919,408,256.00	(83,765,571,299.69)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	4,500,000.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	4,500,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	575,344,268.00	3,165,764,932.69
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	347,651,580.00	2,343,657,781.80
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	227,692,688.00	822,107,150.89
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(575,344,268.00)	(3,161,264,932.69)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	11,915,759,800.00	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	11,915,759,800.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,915,759,800.00	-

"Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл...)
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
4	Валютын ханшийн зөрүү	(7,408,719,094.28)	461,575,948.40
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	900,851,104,693.72	(86,465,260,283.98)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,731,709,823.19	902,582,814,516.91
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	902,582,814,516.91	816,117,554,232.93



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН БИРЖ

“Монголын хөрөнгийн бирж” ХК

Хаяг: Сүхбаатарын талбай-3,
Улаанбаатар 15160, Монгол улс

Утас: (+976)-11-313747

Факс: (+976)-11-325170

Веб хуудас: www.mse.mn

И-мэйл: info@mse.mn



110 ШУДАРГА ЁС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД
АВЛИГА МЭДЭЭЛЭХ УТАС
ЯРИАНЫ ТӨЛБӨРГҮЙ